



**“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**110/35/10 КВ ДАЛАНЗАДГАД ДЭД СТАНЦЫН ХТ-2 35 КВ ХҮЧДЭЛИЙН  
ТРАНСФОРМАТОРТ ЦЭНЭГ ШАВХАГЧ, 110 КВ-Н ТАВАНТОЛГОЙ-ДАЛАНЗАДГАД  
АШ-Н 110/35/10 КВ-ЫН ДАЛАНЗАДГАД ДЭД СТАНЦ ТАЛД НЭГ ФАЗЫН ШУГАМЫН  
ХТ СУУРИЛУУЛАХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН  
БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: “110/35/10 кВ Даланзадгад дэд станцын ХТ-2 35 кВ хүчдэлийн трансформаторт цэнэг шавхагч, 110 кВ-н Тавантолгой-Даланзадгад АШ-н 110/35/10 кВ-ын Даланзадгад дэд станц талд нэг фазын шугамын ХТ суурилуулах”

Тендерийн дугаар: **ЦДҮС-2019/ХА22-3**

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019/08/06

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “110/35/10 кВ Даланзадгад дэд станцын ХТ-2 35 кВ хүчдэлийн трансформаторт цэнэг шавхагч, 110 кВ-н Тавантолгой-Даланзадгад АШ-н 110/35/10 кВ-ын Даланзадгад дэд станц талд нэг фазын шугамын ХТ суурилуулах” гүйцэтгэгчийн тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерийг 2019 оны 08 дугаар сарын 16-ны 10:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг Улаанбаатар хот-36 Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45 “ЦДҮС” ТӨХК-ний байр 3 дугаар давхар 309 тоотод 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 10:10 цагт тендерийг нээнэ.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

***Улаанбаатар хот-21013, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45,***

***“ЦДҮС” ТӨХК-ийн төв байр, 3 дугаар давхар, 309 тоот  
Худалдан авах ажиллагаа, ханган нийлүүлэлтийн хэлтэс  
Утас: 99039494 Факс: 976-70043287***

## Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тендерийн үнэ
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Алдааг залруулах
  - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
    - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

**7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Хоёр.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн нэг жил буюу 2018 оны санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/;</li> <li>- Сүүлийн хоёр жилийн ижил төстэй ажил хийсэн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, ажлын хүлээлцсэн акт/;</li> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулна/</li> <li>- Шүүхийн тодорхойлолт, мэргэжлийн үйл ажиллагаандаа алдаа гаргаж байсан эсэх (харъяалах шүүхийн тодорхойлолт),</li> <li>- Татварын цахим тодорхойлолт.</li> <li>- Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, бусад дагалдах ажил үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх. (<b>шаардлагатай</b>). Хүчдэлийн түвшин: 35кВ болон түүнээс дээш.</li> <li>- Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хавсралт болон гэрээний хамт эх хувиас нь хийсэн хуулбарыг тус тус нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>- Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тодорхойлолт.</li> <li>- Сонгосон бараа материал, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн итгэмжлэл, техникийн тодорхойлолт, дэлгэрэнгүй танилцуулга.</li> <li>- Чанарын удирдлагын ИСО сертификат бүхий үйлдвэрийн бүтээгдэхүүн санал болгоно.</li> <li>- Ажлын даалгаврын дагуу төсөв хийж ирүүлнэ.</li> <li>- Төсвийг Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэж эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна.</li> <li>- Гэрээг хэрэгжүүлэх, удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл. (<i>диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байна.</i>)</li> <li>- Компанийн дэлгэрэнгүй танилцуулга.</li> <li>- Тендерийн хэл Монгол хэл дээр байна.</li> <li>-</li> </ul> <p>Жич: Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 2.1	<p><b>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</b> Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.</p> <p>Огноо: Тендерийг <b>2019 оны 08 дугаар сарын 16-ны өдөр цахим системээр илгээх.</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут.</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот-21013, Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, “ЦДҮС” ТӨХК-ийн төв байр.</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>3-н давхар, 309 тоот</b></p> <p>Огноо: <b>2019 оны 08 дугаар сарын 16-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 10 минут</b></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p><b>“110/35/10 кВ Даланзадгад дэд станцын ХТ-2 35 кВ хүчдэлийн трансформаторт цэнэг шавхагч, 110 кВ-н Тавантолгой-Даланзадгад АШ-н 110/35/10 кВ-ын Даланзадгад дэд станц талд нэг фазын шугамын ХТ суурилуулах” ЦДҮС-2019/ХА22-3</b></p>
Бусад:	Хөнгөлөлт урамшуулал үзүүлэх бол албан бичгээр ирүүлнэ.

Гурав. БАРААНЫ ЖАГСААЛТ БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
110/35/10 кВ Даланзадгад дэд станцын ХТ-2 35 кВ хүчдэлийн трансформаторт цэнэг шавхагч	Техникийн тодорхойлолт	1	Иж бүрдэл	“ЦДҮС” ТӨХК-ийн Говийн бүсийн салбар Даланзадгад дэд станц	14	45	
110/35/10 кВ-ын Даланзадгад дэд станц талд нэг фазын шугамын ХТ		1	Иж бүрдэл				

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

КОМПАНИЙН ТЗБАХ-ЫН АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ "110/35/10 КВ  
ДАЛАНЗАДГАД ДЭД СТАНЦЫН 35 КВ ХТ-2 ХҮЧДЭЛИЙН ТРАНСФОРМАТОРТ  
ЦЭНЭГ ШАВХАГЧ СУУРИЛУУЛАХ АЖИЛ"-ЫН ХҮРЭЭНД ХУДАЛДАН АВАХ ХЭТ  
ХҮЧДЭЛ ХЯЗГААРЛАГЧИЙН ТЕХНИКИЙН ӨГӨГДӨЛ

/ ДАЛАНЗАДГАД Д/С /

### 1. Ашиглалтын нөхцлийн шаардлага

1. Суурилуулалтын нөхцөл: Гадаа
2. Суурилуулах өндөр: далайн түвшнээс дээш 1350≤
3. Орчны температур: -45°C - +45°C
4. Газар хөдлөлтийн зэрэг: 7-8 балл
5. Бохирдлын зэрэг : IY
6. Тусгаарлагын хийц: Шаазан
7. Салхины хурд: 38 м/сек
8. Харьцангуй чийгшил: ≥80%
9. Мөсжилтийн зэрэг : 10 мм
10. Зориулалт: Дэд станцын тоног төхөөрөмжийг хамгаалах
11. Гадна тусгаарлагын материал: Полимер

### 2. Техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Техникийн өгөгдөл
1	Системийн хэвийн хүчдэл	кВ	35
2	Системийн хамгийн их хүчдэл-Us	кВ	40,5
3	Ажлын үргэлжилсэн хүчдэл- Uc	кВ	≥70
5	Хэвийн цэнэгжилтийн гүйдэл 8/20	кА	10
6	Хэвийн 4/10 мкс импульсын их гүйдэл тэсвэрлэх чадвар	кА	100
7	Системийн богино залгааны гүйдлийн хамгийн их утга	кА	40
8	Хэвийн давтамж	гц	50
9	Хийц		Металлын исэлт

10	2 мсек-ын гүйдлийн импульс тэсвэрлэх чадвар		A	≥550
12	Гадаргуугаар гүйдэл нэвчих зай		мм	≥1350
13	Хэсэгчилсэн цахилалтын зэрэг		pC	10
14	Гадна эх биеийн тусгаарлага	Үйлдвэрлэлийн давтамжтай тэсвэрлэх хүчдэл	кВ	≥118
		Аянгын импульсын тэсвэрлэх хүчдэл	кВ	≥215

**Жич:** Y5WI-51/134 маркийн хэт хүчдэл хязгаарлагчтай дүйцэхүйц үзүүлэлттэй байх

**Стандартууд :** IEC 60099-5 , IEC 62271, IEC 60099-4



1115105450 268522  
ТӨХК

КОМПАНИЙН ТЗБАХ-ЫН АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ “110 КВ-ЫН  
ТАВАНТОЛГОЙ-ДАЛАНЗАДГАД ЦДАШ-ЫН ДАЛАНЗАДГАД ДЭД СТАНЦ ТАЛД  
ХҮЧДЭЛИЙН ТРАНСФОРМАТОР СУУРИЛУУЛАХ АЖИЛ”-ЫН ХҮРЭЭНД  
НИЙЛҮҮЛЭХ ХҮЧДЭЛИЙН ТРАНСФОРМАТОРЫН ТЕХНИКИЙН ӨГӨГДӨЛ

/ ДАЛАНЗАДГАД Д/С /

**1. Ашиглалтын нөхцлийн шаардлага**

1. Суурилуулалтын нөхцөл: Гадаа
2. Суурилуулах өндөр: далайн түвшнээс дээш  $1350 \leq$
3. Орчны температур:  $-45^{\circ}\text{C} - +45^{\circ}\text{C}$
4. Газар хөдлөлтийн зэрэг: 7-8 балл
5. Бохирдлын зэрэг : IY
6. Салхины хурд:  $\geq 35$  м/сек
7. Харьцангуй чийгшил:  $\geq 80\%$
8. Гадна тусгаарлагын материал: Шаазан
9. Хийц: 1 фазын , багтаамжийн

**2. Хүчдэлийн трансформаторын техникийн үзүүлэлт**

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Техникийн өгөгдөл
1	Зөвшөөрөгдөх хэвийн хүчдэл	кВ	110
2	Системийн хамгийн их зөвшөөрөгдөх хүчдэл	кВ	126
3	Зөвшөөрөгдөх давтамж	гц	50
4	Нарийвчлалын зэрэг		Тоолуурын хэлхээ-0,2 Хэмжүүрийн хэлхээ-0,5 РХА-ын хэлхээ-3P
5	Хүчдэлийн түвшин	В	$110000/\sqrt{3} / 100 / \sqrt{3} / 100 / \sqrt{3} / 100$
6	Зөвшөөрөгдөх чадал	ВА	100/150/300

7	Үйлдвэрлэлийн давтамжтай, тэсвэрлэх хүчдлийн хэмжээ	кВ	230
8	Аянгын бүрэн импульсыг тэсвэрлэх хүчдэл /LIVV/	кВ	480
9	Цэнэг гулсах зай	мм	>2050

Стандартууд : IEC 60044 , IEC 60071

**Материалын жагсаалт:**

<b>Д/д</b>	<b>Материалын нэр</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>Тоо ширхэг</b>
1	40x50 хэмжээтэй хайрцаг	ш	1
2	Салбарлалтын хавчаар т зажим ф 120	ш	1
3	Утас АС-120мм <sup>2</sup>	м	40
4	Хар тос	кг	12,4
5	Хүчдлийн хувьсгуур 1 фазын	ш	1
6	Хүчдлийн клем	хайрцаг	1
7	Шон УСО-3а	ш	1
8	Электрод Э-42	кг	0,34
9	Багцлагч	ш	2
10	Автомат АС 100 в 2а, Блок контакттай	ком	2
11	Автомат DC 220 В Блок контакттай	ком	2
12	Аппаратны хавчаар а2а-120	ш	1
13	Газардуулгын шин	м	10
14	Вырка	боодол	1
15	Кгвв 2.5x7 кабель /гүйдлийн хэлхээнд/	м	90
16	Кабель кввг 2x2.5мм <sup>2</sup>	м	100
17	0-ийн шин	ш	2
18	2.5мм –ийн зөөлөн зэс утас	м	100
19	2.5-4 төгсгөвч /шулуун, ацтай/	боодол	3
20	1x2.5мм зэс уян кабель	боодол	2
21	U боолт	ш	1
22	Серго	ш	1
23	Ушко	ш	1
24	Зевно	ш	1
25	Цемент	уут	2

**Хийгдэх ажил**

<b>Д/д</b>	<b>Ажилбарын нэр</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>Тоо ширхэг</b>
1	110Кв-ын хүчдлийн хувьсгуур суурилуулах	ком	1
2	0,22м <sup>3</sup> хүртэл эзлэхүүнтэй УСО-3 маркийн төмөр бетон шон угсарч босгох	ш	1
3	1кг хүртэл жинтэй кабелийг сувагт сунгах	м	390
4	160мм <sup>2</sup> хүртэл огтлолтой газардуулгын шинийг шуудуунд угсрах	м	10

5	110 кВ-ын 185мм <sup>2</sup> хүртэл огтлолтой утсаар буулт хийх	1 буулт 3 фаз	1
6	ХТ –ийн холболтын хавчаарын хайрцаг суурилуулах	ш	1

**Материалын жагсаалт:**

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Төмөр эдлэлийн репко будаг	кг	1
2	Цэнэг шавхагч тоолуур	ш	3
3	Цэнэг шавхагч ртв-35кВ	ш	3
4	Аппартны хавчаар А2А-120	ш	12
5	Электрод э-46	кг	5
6	С-14 швеллер	м	6

**Хийгдэх ажил**

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Суурин төмөр хийц бэлтгэх	м	6
2	Төмөр хийцийн будаг	м	6
3	35 кВ-ын цэнэг шавхагч 3-н тоолуурын хамт суурилуулах	Ком	3

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал  
Б.Нямсамбуу танаа**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа жил байна.  |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| <b>7. Төлбөр</b>  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| <b>9. Алданги оногдуулах</b>                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| <b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |



**11. Маргааныг  
шийдвэрлэх**

11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа.ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Барааг хүлээн авахаас өмнө мэдээлэл технологийн хэлтсээр шалгуулж туршилт хийлгүүлнэ.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none"><li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li><li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li><li>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li><li>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li></ol> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>Чанарын баталгаат хугацаа 12 сар байна.</p>  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн <b>95</b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн дагуу Урьдчилгаа төлбөр олгож болно.</p>  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</b>                              | <p>9.1. Алданги оногдуулах хувь: Гэрээний үнийн <b>0.05%</b> байна.</p> <p>Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн <b>5%</b>-иас хэтрэхгүй.</p>   |

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*